



Гадаад хэргийн яамны 2005 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт



ҮАГ

***Зардал хэмнэх боломжийг
ашиглахгүй байна***

**УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны хүсэлт,
Үндэсний аудитын газрын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний
дагуу хийсэн аудитын тайлан**

Улаанбаатар 2006 оны 6 дугаар сар

Агуулга

	Товчилсон үгсийн жагсаалт	2
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
ҮАГ-ын нэгдүгээр газар	Бүлэг 1	
<i>Тэргүүлэх аудитор</i> <i>Д.Ганбилэг</i>	Яам өөрийн орлого болон гадаадад суугаа ДТГ-уудын орлогыг бодитой хянаж чадахгүй байна	
<i>Аудитын менежер</i> <i>Ж.Батсайхан</i>		
<i>Ахлах аудитор</i> <i>Г.Цэдэнбалжир</i>	Яам болон ДТГ-ууд өөрийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж чадахгүй байна.	4
<i>Шинжээч</i> <i>Ц.Цолмон</i>		
2006 оны 4 дүгээр сар	Гадаадад суугаа зарим ДТГ-ын орлогыг төвлөрүүлж чадахгүй байна.	5
Тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:	Зөвлөмж 1	6
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	Бүлэг 2	
	Төсөвт зардлын гүйцэтгэлд тавих дотоод хяналт үгүйлэгдэж байна.	
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	Төсөвт зардлыг бодитой төлөвлөж чадахгүй байна	7
ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын 4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-6, Улаанбаатар-46</i> Монгол Улс	Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахгүй байна.	9
	Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй байна	14
	Зөвлөмж 2	15
	Холбогдох байгууллагын санал	16
	<u>Хавсралтууд:</u>	
	ГХЯ-ны 3 жилийн төсөвт зардлын судалгаа	
	ДТГ-уудын 3 жилийн төсөвт зардлын судалгаа	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд ГХЯ-ны төсвийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийв.

Дараахь асуудалд аудит хийж, дүгнэлт өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

- Яам өөрийн орлого болон ДТГ-уудын орлогыг бодитой хянаж байна уу?
- ГХЯ-ны төсөвт зардлын бүтэц оновчтой байна уу?

Эдгээр зорилтын хүрээнд ГХЯ, ДТГ-уудын 2005 оны үйл ажиллагаатай холбоотой тайлан, баримт материалыг түүвэрлэн шалгав.

Аудитад баримт материалд дүн шинжилгээ, ярилцлага, ажиглалт хийх, тулган баталгаажуулах зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглав. Үүнд:

- Төрийн сангаас олгосон санхүүжилтийн талаарх судалгаа, тодруулга авах
- ДТГ-уудаас өөрийн орлогын төлөвлөгөөний дагуу улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн судалгаа, тодруулга авах
- Төсөвт зардлын гүйцэтгэлийн судалгаа, тодруулга авах, дүн шинжилгээ хийх, зардлын гүйцэтгэлийг бусад байгууллагатай тулган баталгаажуулах
- Ажлын гүйцэтгэлийн баримт материалтай танилцах, шаардлагатай үед холбогдох бусад байгууллагаас тодруулга авах
- Гадаад томилолтын зардлын талаар холбогдох хүмүүстэй ярилцах, асууж тодруулах

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэглэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Яам өөрийн орлого болон гадаадад суугаа ДТГ-уудын орлогыг бодитой хянаж чадахгүй байна.

Танилцуулга

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 248 дугаар тогтоолын дагуу ГХЯ Бодлого, төлөвлөлт, мэдээлэл үнэлгээний газар, Хөрш орнуудын газар, Азийн газар, Америк, Ойрхи дорнод, Африкийн газар, Европын газар, Олон талт хамтын ажиллагааны газар, Гэрээ, эрх зүйн газар, Консулын газар, Төрийн захиргааны удирдлагын газар, Ёслолын хэлтэс, Гадаад хэргийн төв архив гэсэн бүтцээр 102 хүний орон тоотой ажиллаж байна.

ГХЯ төрийн гадаад бодлого, гадаад орон, олон улсын байгууллагатай улс төрийн талаархи хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрийн асуудал болон түүнд тавих хяналт, гадаад эдийн засгийн харилцаа, гадаадад байгаа Монгол Улсын иргэний эрх ашгийг хамгаалах, виз, консулын асуудал, гадаад оронтой хүмүүнлэгийн чиглэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

ГХЯ 2005 онд төсвийн урсгал зардалд 397,2 сая, олон улсын байгууллагын гишүүний татварт 470,1 сая, бүгд 867,3 сая төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр урсгал зардалд 397,2 сая, олон улсын гишүүний татварт 298,1 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авчээ.

Монгол Улсаас гадаад улсад суугаа ДТГ-уудаас визийн наадаг хуудасны орлого 406,6 сая, ГХЯ-ны Консулын газраар визийн үйлчилгээ хийсэн төлбөр 57,3 сая, яамны хурлын заалны түрээс, архивын үйлчилгээний төлбөр 4,7 сая, бүгд 468,6 сая төгрөг төвлөрүүлжээ.

Монгол Улсаас гадаад улсад суугаа 33 ДТГ-ууд улсын төсвөөс 3724,9 сая төгрөгийн санхүүжилт авахаас 3571,9 сая төгрөгийн санхүүжилт авч, 153,0 сая төгрөгийг ДТГ-уудын өөрийн орлогын давсан хэсгээр санхүүжүүлсэн байна.


1.Яам болон ДТГ-ууд өөрийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж чадахгүй байна.

1.1 ГХЯ 2005 оны өөрийн орлогыг төлөвлөхдөө визийн наадаг хуудасны орлого, яамны КГ-ын визийн үйлчилгээний төлбөр, хурлын заалны түрээсийн орлого, архивын үйлчилгээ хийлгэсэн төлбөр зэрэг орлогыг өөрийн орлогын төлөвлөгөөнд тусгаагүй нь орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн мэт харагдахад хүргэжээ.

1.2 Улсын төсвөөс авах олон улсын гишүүний татварын санхүүжилт 172,0 сая төгрөгөөр дутуу хийгдсэн бөгөөд түүнийг Сангийн яам шууд шилжүүлжээ.

1.3 ГХЯ-ны өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулсан графикаас харахад 2003, 2004 онд өөрийн орлогын төлөвлөгөөг тогтмол 55.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2003 онд 2.7, 2004 онд 3.7 дахин биелүүлжээ. Харин 2005 онд өөрийн орлого төлөвлөөгүй байхад 468.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарчээ.


ГХЯ-ны өөрийн орлого



Энэ байдлаас үзэхэд ГХЯ өөрийн орлогыг бодитой төлөвлөж чадахгүй байна.

1.4 ДТГ-ууд 2005 оны үндсэн болон бусад үйл ажиллагааны орлогыг 5576,8 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8295,4 сая төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөөг 2718,6 сая төгрөг буюу 48,7 хувиар давуулан биелүүлжээ. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 3 жилийн байдлаар үзүүлбэл:

Дипломат төлөөлөгчийн газруудын өөрийн орлого



Үүнээс үзэхэд ДТГ-уудын өөрийн орлогыг бодитой төлөвлөж чадаагүй байна.

2. Гадаадад суугаа зарим ДТГ-ын орлогыг төвлөрүүлж чадахгүй байна.

2.1 Нийт дүнгээр ДТГ-ууд төв төрийн санд 1701,3 сая төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3624,2 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 1922,9 сая төгрөг буюу 213,0 хувиар давуулан биелүүлжээ.

2.2 Төвд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 2005 онд Сөүл дэх ЭСЯ, Эрхүү, Хөх хот, Кызыл дэх ЕКГ, Эрээн дэх КГ давуулан биелүүлсэн боловч Бээжин дэх ЭСЯ 22,4 мянган ам.доллар буюу 29,3 сая төгрөгөөр, Токио дахь ЭСЯ 15,0 мянган ам.доллар буюу 18,1 сая төгрөгөөр тасалдуулжээ. Токио дахь ЭСЯ 2004 онд улсын төсөвт 22,8 сая төгрөг төвлөрүүлэхээс нэг ч төгрөг төвлөрүүлэлгүй орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

Зөвлөмж 1

Сангийн сайд Н.Баяртсайханд:

- ГХЯ-ны орлого, зарлагын төлөвлөгөөг тухайн байгууллагын саналыг үндэслэн бодитой, үндэслэлтэй хянаж баталж байх.

Гадаад хэргийн сайд Н.Энхболдод:

- ГХЯ, ДТГ-уудын өөрийн орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, туслах үйл ажиллагааны /визийн наадаг хуудас, КГ-ын визийн үйлчилгээ, хурлын заалны түрээс, архивын үйлчилгээ/ орлогыг төсвийн орлогын төлөвлөгөөнд тусгаж байх.
- Монгол Улсаас гадаад оронд суугаа ЭСЯ, ДТГ-уудаас визийн наадаг хуудасны зарцуулалтын тайланг бүрэн гаргуулах, тайлан тооцоог шалгаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах.
- Зарим ДТГ-ын төсвийн орлогын төлөвлөгөө тасалдуулсан шалтгааныг судалж, зохих арга хэмжээ авах.

Бүлэг 2

Төсөвт зардлын гүйцэтгэлд тавих
дотоод хяналт үгүйлэгдэж байна.

Танилцуулга


ГХЯ-ны урсгал зардалд 2005 онд 867,4 сая төгрөг батлагдсан бөгөөд Сангийн сайдын 2005 оны 308 дугаар тушаалаар 150,0 сая төгрөгөөр нэмэгдэж, бүгд 1017,4 сая төгрөг зарцуулах болжээ.

Монгол Улсаас гадаад орнуудад суугаа 33 ДТГ 2005 онд 7576,5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7989,4 сая төгрөг зарцуулж, төсөвт зардлыг 412,8 сая төгрөг буюу 5,4 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.

3.Төсөвт зардлыг бодитой төлөвлөж чадахгүй байна

3.1. ГХЯ-ны 2005 оны урсгал зардлын батлагдсан төлөвлөгөө 867,3 сая төгрөг бөгөөд (Сангийн сайдын 2005 оны 308 дугаар тушаалаар 150,0 сая төгрөг нэмэгдсэнийг эс тооцвол), гүйцэтгэлээр 897,8 сая төгрөг зарцуулж, төсөвт зардлыг хэмнэсэн бус харин 30,5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. ГХЯ-ны төсөвт зардлын гүйцэтгэлийн 3 жилийн судалгааг үзүүлбэл:

Төсөвт зардлын гүйцэтгэл




3.2 ГХЯ 2005 онд төсөвт зардлын 18 зүйлээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бичиг хэргийн зардал, тээвэр шатахууны зардал, гадаад арга хэмжээний зардал гэх мэт 13 зүйлийг бүгд 52,4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь зардлыг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна. Тухайлбал:


- **Бичиг хэргийн зардал.** Тус яамнаас КГ-т олгосон дипломат болон албан паспортын үнэ 4,9 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд бичсэн, төсөвт тусгагдаагүй архивын материалын хавтас, цаасан хайрцагны үнэнд бүгд 3,0

сая төгрөг зарцуулж, түүнийг орлогод авалгүй зардалд бичсэн, олшруулагч, хувилагчийн хор болон компьютерийн сэлбэг хэрэгслийн үнэнд 12,9 сая төгрөг, бусад бичиг хэргийн зүйлс 14.3 сая төгрөг байна.

Бичиг хэргийн зардлын гүйцэтгэлийг 3 жилээр харуулбал:



- **Гадаад арга хэмжээний зардал** 2005 онд гүйцэтгэлээр 193,8 сая төгрөг болж батлагдсан төсвийг 11,2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Гадаад арга хэмжээний зардлыг 3 жилээр харьцуулан харуулбал:




Гадаад арга хэмжээний зардал жил дараалан өсч, бас төлөвлөгөөт хэмжээнээс хэтэрч байна. Уг хэтрэлтийг өөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан хэсгээр санхүүжүүлдэг байна.

2005 оны гадаад арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

№	Гадаад арга хэмжээний зардал	Тоо хэмжээ	Зарцуулсан хөрөнгийн дүн /сая төгрөг/	Эзлэх хувийн жин	
				тоо хэмжээнд	үнийн дүнд
1	Төлөвлөгөөт	24	122,9	57,2	63,4
2	Төлөвлөгөөт бус	18	70,9	42,8	36,6
	Дүн	42	193,8	100	100

Төлөвлөгөөт бус арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан нь зардал хэтрэх нэг шалтгаан болжээ.




Гадаад арга хэмжээний нийт зардлын 61,5 хувь онгоцны зардал, 28,1 хувь зочид буудлын зардал, 6,8 хувь томилолтын зардал, 1,9 хувь бэлэг дурсгалын зардал, 1,6 хувь бусад зардал байгаа юм. Үүнээс байр, томилолт, бэлэг дурсгал, бусад зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх шаардлагатай байна.

3.3 Монгол Улсаас гадаад орнуудад суугаа 33 Дипломат төлөөлөгчийн газар 2005 онд 7576,5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 7989,4 сая төгрөг зарцуулж, төсөвт зардлыг 412,8 сая төгрөг буюу 5,4 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.

Үүнээс төсөвт зардлаа 20 ДТГ бүгд 559,5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ. Тухайлбал, Москва дахь ЭСЯ 56,8 сая, Улаан-Үд дэх КГ 31,3 сая, Парис дахь ЭСЯ 63,3 сая, Лондон дахь ЭСЯ 83,4 сая, Берлин дэх ЭСЯ 44,7 сая, Нью-Йорк дахь БТГ 44,4 сая төгрөг гэх мэт. 2004 онд төсөвт зардлаа 17 ДТГ хэтрүүлж байсан бол 2005 онд 3-аар нэмэгдсэн байна.


ДТГ-уудын урсгал зардлын төсөв болон гүйцэтгэл жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь дараахь графикаас харагдаж байна.



4.Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахгүй байна.

4.1 ГХЯ ЗГ-ын тогтоолоор баталсан заавар журмыг мөрдөж ажиллаагүйгээс зарим төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулжээ. Тухайлбал;

- **Шуудан холбооны зардал.** ГХЯ 2005 онд шуудан холбооны зардалд 33,5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 35,1 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 2,1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ. Шуудан холбооны зардлын бүтцийг графикаар харуулбал:




Шуудан холбооны зардлын 31,7 сая төгрөг буюу 88,9 хувь нь үүрэн болон суурин телефон утасны зардал эзэлж байна. Тухайлбал, сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын гар утасны төлбөр 10,2 сая төгрөг, 3... дугаараар эхэлсэн 9 утасны төлбөр 11,5 сая төгрөг, 26... дугаартай төрийн холбооны 97 хэрэглэгчтэй утасны төлбөрт 10,1 сая төгрөг гэх мэт.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив”-ийг мөрдөж ажиллахгүй байна. Энэ тогтоолоор Засгийн газрын гишүүн улс хоорондын ярианы эрхтэйгээр нэг сард 150,0 мянган төгрөгөөс, бусад албан тушаалтан улс хоорондын ярианы эрхгүйгээр нэг сард 65,0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байхаар тогтоожээ.

- Энэ тогтоолын заалтаар тооцож үзвэл жилийн нормативт хэмжээнээс сайд Ц.Мөнх-Оргилын гар утасны төлбөр 312,4 мянган төгрөгөөр, дэд сайд А.Баттөрийнх 1129,8 мянган төгрөгөөр буюу 2,4 дахин их, төрийн нарийн бичгийн дарга Р.Алтангэрэлийнх 5766,9 мянган төгрөгөөр буюу 9,9 дахин их байна.
- МЦХК-иас 3... гэсэн дугаараар эхэлсэн 9 утас ашигласны ярианы төлбөр 2005 онд 11552,4 мянган төгрөг гарчээ. Үүнээс ГХЯ-ны факсын утас 4474,7 мянга, КГ-ын даргын утас 2248,8 мянга, төрийн нарийн бичгийн даргын туслахын утас 1666,3 мянга, бүгд 8389,8 мянган төгрөг болж байгаа нь 3... –аар эхэлсэн дугаартай утасны төлбөрийн 72,6 хувийг эзлэж байна. Эдгээр утасны сарын төлбөрийн хамгийн бага нь 138,8 мянган төгрөг, их нь 372,9 мянган төгрөг байна.
- ГХЯ-нд төрийн холбооны 97 утас ашиглагдаж байгаа бөгөөд энэхүү утасны төлбөр 2005 онд 12491,4 мянган төгрөг болж, 1 утасны сарын төлбөр дунджаар 10,7 мянган төгрөг байна.

Үүнээс үзэхэд ГХЯ утасны төлбөрийг бууруулах боломж байна.

- **Тээвэр шатахууны зардал** 2005 онд 18,5 сая төгрөг болж, батлагдсан төсөв 6,2 сая төгрөгөөр хэтэрсэн байна. ГХЯ-ны суудлын автомашины үйлчилгээг ДБУААГ-ын авто бааз хөнгөлттэй үнээр (1 км нь 75-90 төгрөг) үйлчилж байна.



ДБУААГ-аас гаргасан судалгаагаар тус яам 2005 онд бүгд 225,509 км буюу 18,5 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд зарцуулсан байна. Үүнээс сайд 51,563 км буюу 4,1 сая, дэд сайд (А.Баттөр) 35,642 км буюу 2,85 сая, Төрийн нарийн бичгийн дарга (Р.Алтангэрэл) 12,544 км буюу 1,0 сая, Ёслолын хэлтэс (О.Дамбийням) 49709 км буюу 4,1 сая, ТЗУГ (Т.Батбаатар) 28,428 км буюу 2,3 сая, бүгд 177,886 км буюу 14,35 сая төгрөг зарцуулж байгаа нь нийт явсан км-ын 78,9 хувь, тээврийн зардлын үнийн дүнгийн 77,6 хувийг эзэлж байна. Бусад газар хэлтсүүд нийт тээврийн зардлын 4,15 сая төгрөг 22,4 хувийг эзэлж байна.

“Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай” Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын 2-т “Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын авто машиныг хотын дотор хуанлийн хоногт /баярын болон долоо хоног бүрийн амралтын өдрийг оролцуулан/ дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 80 км-ээс хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар” тогтоосон байдаг.

Энэ журмаар сайд Ц.Мөнх-Оргил 1083.7 мянга, дэд сайд А.Баттөр 1196.2 мянга, Ёслолын хэлтсийн дарга О.Дамбийням 1596.3 мянга, ТЗУГ-ын дарга Т.Батбаатар 320.3 мянган төгрөгөөр тус тус шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулжээ.

ГХЯ 2004 онд 12,8 сая төгрөгийг тээврийн зардалд зарцуулж байсан бол 2005 онд 18,5 сая төгрөг буюу 5,7 сая төгрөг буюу 44,5 хувиар нэмэгджээ. Иймд удирдлагын тээврийн зардлыг бууруулах шаардлагатай байна.

- **Гадаад албан томилолтын зардлыг** тооцохдоо СЭЗС-ийн 2001 оны 188 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах, санхүүжүүлэх, тайлагнах журам”-аар гадаад албан томилолт, зочид буудлын зардлын хэмжээг мөрдөж ажиллахгүй байна. Тухайлбал, СЭЗС-ийн баталсан журмаар гадаад томилолтын зардал АНУ-д зочид буудал 50 ам.доллар, зам хоног 25 ам.доллар, бүгд 75 ам.доллар, Англид зочид буудал 50 ам.доллар, зам хоногт 30 ам.доллар, бүгд 80 ам.доллараас хэтрүүлэхгүй байхаар заажээ. Гэтэл доорхи баримтыг үзвэл:

- **Баримт 1.** 2005 оны 9 дүгээр сард Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганд оролцсон ГХЯ-ны сайд Мөнх-Оргил, тус яамны Ёслолын хэлтсийн дарга О.Дамбийням нарын буудлын хөлс 1 өдрийнх 500 ам.доллараар төлөвлөгдөж байгаа нь СЭЗС-ын тогтоосон тарифаас 10 дахин их үнээр төлөвлөгдөж байна.
- **Баримт 2.** ГХЯ-ны дэд сайд А.Баттөр, Европын газрын захирал Я.Батсуурь, тус газрын атташе Х.Мандахцэцэг нар 2005 оны 3 дугаар сард Монгол Британийн дугуй ширээний уулзалтад оролцоход Лондон хотод буудлын зардлыг 1 хоногийн 150 фунт стирлингээр (288 ам.доллар) төлөвлөсөн нь СЭЗС-ын баталсан журмаас 5,7 дахин их байна.

4.2 Сангийн сайдын энэ журам тохирохгүй гэдэг шалтгаанаар ГХЯ-ны зарим удирдлага, ажилтнууд төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах талаар санаачлагатай ажиллахгүй байна.

Баримт № 2 жишээнээс үзэхэд төсвийг зохиосон ГХЯ-ны Европын газрын атташе Г.Гантулгаас буудлын зардлыг төлөвлөсөн үндэслэлийг тодруулахад, буудлын зардлыг төлөвлөж тооцохдоо тухайн улсад суугаа ЭСЯ-наас үнийн саналыг үндэслэсэн гэх боловч энэ талаар Лондонд суугаа ЭСЯ-наас тодруулсан баримт байхгүй байна.

Интернетээс Лондон хот дахь ROYAL GARDEN HOTEL-ын талаархи мэдээлэлтэй танилцахад энэ зочид буудал зэрэглэлийн хувьд 5 таван хошуутай буудал байна. Тус буудлын захиргаанд Монголын талын төлөөлөгчдийг байрлуулсан нэхэмжлэлийг баталгаажуулахаар 2006 оны 3 дугаар сард хүсэлт гаргасан.

Уг хүсэлтийн дагуу 2006.05.22-ны өдөр хариу факс ирүүлжээ. Үүнд:

- Ноён А.Баттөр, Я.Батсуурь нар нь хоёулаа буудлын захиалгаа хүчингүй болгосныг албан ёсоор мэдэгдэж байна.
- Хатагтай Х.Мандахцэцэг нь 2005 оны 3 дугаар сард болон бусад цаг хугацаанд ROYAL GARDEN HOTEL буудалд байрлаж байсан ямар нэгэн мэдээлэл байхгүй байна.
- Түүний үзүүлсэн нэхэмжлэх нь манай буудлын 0647 дугаар өрөөнд буудалласан ноён Ичинхорлоогийн Сэр-Одын №138296/1 дугаартай нэхэмжлэх байгааг та бүхэн харж болох юм гэсэн хариу ирүүлснээс

үзэхэд дээрх 3 төлөөлөгчид нь уг зочид буудалд огт байрлаагүй байна. Иймд энэ зочид буудалд байрлаж тушаасан гэх 2812,5 фунтстерлингийн баримт албан ёсны бус гэж үзэж байна.

Дээрх албан тушаалтнуудын Ирланд, Исланд, Лондонд хийсэн ажлын айлчлал, дугуй ширээний уулзалтад бүгд 13119 ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд тус яамны нягтлан бодогч Д.Байгалмаа зардлын гүйцэтгэлийг жинхэнэ зарцуулалтаар нь тооцолгүй төсвөөр нь зарлага болгон тооцжээ. Гэтэл гүйцэтгэлээр тооцож үзвэл дээрх нэр бүхий 3 хүнд зочид буудлын үнэ, зам хоног, унааны зардлын зөрүүг тооцоогүйгээс бүгд 5295 ам.доллар буюу 6465,2 мянган төгрөг илүү олгогдсоныг төлүүлэхээр төлбөрийн акт бичив.


Баримт № 3. 2005 оны 9 дүгээр сард Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганд оролцсон ГХЯ-ны ОТХАГ-ын 3 дугаар нарийн бичгийн дарга А.Амарсанаа Нью-Йорк хот дахь БТГ-ын зочид буудалд байрлахдаа буудлын хөлсөнд 2400 ам.доллар төлсөн (Байнгын төлөөлөгч Ч.Баатараас E-mail –ээр тодруулга авсан) атал 3200 ам.доллар төлсөн гэсэн кассын өөр баримтаар томилолтын тооцоо хийснээс томилолтын тооцооны зөрүү 800 ам.доллар буюу 950.4 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичиж аудитын явцад төлүүлж барагдууллаа.

Баримт № 4. Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдоржийн Сингапур Улсад айлчлах төлөөлөгчийн бүрэлдэхүүнд оролцох ГХЯ-ны ОТХАГ-ын дэд захирал П.Гансүх, Азийн газрын дэд захирал Ж.Сэрээжав нар зочид буудлын төлбөрийн тооцоог хийхдээ төлбөрийг сингапур доллараар төлсөн атал ГХЯ-ны санхүүтэй ам.доллараар хийснээс валютын ханшны зөрүү гарч, П.Гансүх 199.65 ам.доллар буюу 237,1 мянган төгрөг, Ж.Сэрээжав 132.80 ам.доллар буюу 157,7 мянган төгрөг бүгд 394,8 мянган төгрөг илүү олгосныг (Монгол Улсаас Сингапур Улсад суугаа ЕК-ын үүрэг гүйцэтгэгч Д.Гэрэлмаатай утсаар ярьж, e-майл хаягаар тодруулга авсан) төлүүлэхээр төлбөрийн акт бичиж төлбөр хариуцагч нараар аудитын явцад төлүүлж барагдуулав.

Баримт № 5. Астана хотод болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагуудын гишүүн орнуудын уулзалтад ГХ-ийн сайд Ц.Мөнх-Оргил, БТМҮГ-ын захирал Б.Сувд, ЁХ-ийн дарга О.Дамбийням, ХОГ-ын 1-р нарийн бичгийн дарга нар оролцжээ. Тэдний томилолтын тооцоог шалгаж үзэхэд сайд Ц.Мөнх-Оргилын зочид буудлын 642 ам.доллар, VIP заалны зардал 300 ам.долларын баримт байхгүйн зэрэгцээ дээрх 4 хүнд томилолтын зардалд хүн тус бүрт 30 ам.доллар бүгд 120 ам.долларыг илүү олгосон зөрчлийг арилгуулахаар албан шаардлага бичив.

- **Гадаад зочны зардал.** 2005 онд ГХЯ-ны шугамаар Монгол Улсад айлчлах төлөөлөгчдийн зардлыг 18,1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 20,2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 2,0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Гадаад зочны зардлын бүтцийг авч үзвэл :



Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолоор баталсан “Төр, засгийн шугамаар гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив, бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам” мөрдөгдөж байгаа боловч хүлээн авалтын арга хэмжээнд оролцож байгаа хүний тоо олон байгаагаас төсөвт зардал хэтэрч байна.

- **Цалингийн зардал.** ГХЯ эхний хагас жилд 102 хүн ажиллахаас 108 орон тоотой ажиллаж, цалингийн зардлыг 6,8 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,8 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.
- **Бусад:** 2005 оны жилийн эцэст ГХЯ-ны нярав Д.Жадамбаагийн хариуцлагад Дипломат паспорт 3640 ширхэг, Албан паспорт 7040 ширхэг үлдэгдэлтэй байна. Энэ нь 3 жилийн нөөц гэж албаны хүмүүс хэлж байгаа юм. Гэтэл 2006 онд 27,0 мянган еврогоор 12,0 мянган ширхэг (албан паспорт 10,000 ш, дипломат паспорт 2,000 ш) паспортыг шинээр хийлгэсэн байна. Төсөвт тусгагдаагүй, шинээр хийлгэх болон хөрөнгийн асуудлыг Засгийн газраас шийдвэрлээгүй байхад захиалаад хийлгэсэн байна.

5.Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй байна.

5.1 ГХЯ-нд ГХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний багцын тайлан гаргах, дүн шинжилгээ хийх бие даасан санхүү, эдийн засгийн албагүй боловч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ДБҮААГ-ын Санхүү, эдийн засгийн хэлтсээс тус яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг удирдан зохицуулж байна.

5.2 ГХЯ-ны харилцах дансны гүйлгээний 1 дүгээр гарын үсгийг Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Т.Батбаатар, 2 дугаар гарын үсгийг ДБҮААГ-ын СЭЗХ-ийн дарга Н.Цэрэнханд зурж байгаа бөгөөд валют болон төгрөгийн кассын орлого, зарлагын баримтад 1 дүгээр гарын үсэг зурагдахгүй 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Байгалмаа гарын үсэг зурж байна.

5.3 Мөнгөн хөрөнгийн кассын зарлагын баримтад 1-р гарын үсэг зурагдахгүй байгаа нь мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналт хангалтгүй байгааг харуулж байна. “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 1-д “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирлага хэрэгжүүлнэ” гэсэн заалт хэрэгжихгүй байна.

5.4 “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 12.1.1, 12.1.7 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 183 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн в-д “Харъяа байгууллагуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн улирлын тайланд хийсэн нэгдсэн дүгнэлт, танилцуулгыг жил бүрийн 5, 8, 11 дүгээр сарын 10-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайлан, дүгнэлтийг дараа оны 3 дугаар сарын 10-ны дотор Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлж байсугай” гэж заасны дагуу “Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан”-г гаргаж байх үүргийг ерөнхий менежер, төсвийн ерөнхий нягтлан бодогч нар хүлээсэн байдаг. Гэтэл энэ үүргийг хэрэгжүүлээгүй, 2005 онд бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг гаргаагүй байна.

ЗӨВЛӨМЖ: 2

Сангийн сайд Н.Баяртсайханд:


- СЭЗС-ийн 2001 оны 188 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын зарим заалт өнөөгийн шаардлагад нийцэхгүй байгааг судлан үзэж, зохих журмын дагуу шийдвэрлэх.

Гадаад хэргийн сайд Н.Энхболдод:

- Төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулахыг зогсоож, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байх,
- Төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан ГХЯ-ны болон ДТГ-уудын удирдлагуудтай хариуцлага тооцох,
- Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах ажлыг зохион байгуулж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох,
- Гадаад томилолтын зардлын тооцоог холбогдох хүмүүсээр гаргуулж, албан ёсны баримтыг үндэслэн зарлага болгож байх,
- Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны зардлын норматив”, 1996 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай” журам, Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолоор баталсан “Төр, засгийн шугамаар гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив, бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг мөрдөж ажиллах.
- Дотоод хяналтын тогтолцоог сайжруулах үүднээс орон тоондоо багтаан санхүү, эдийн засгийн албыг байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх.

Холбогдох байгууллагын санал

Гадаад
хэргийн
яам


**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН САЙД**
210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7А, Утас: 31-13-11, Факс: 32-21-27
E-mail: mongmer@magicnet.mn http://www.extrin.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР ЕРӨНХИЙ АУДИТОР
Л.ЖАВЗМАА ТАНАА

2006-05.12 № 09/1947
танай _____-ны № _____-г

Аудитын тайланд санал өгөх тухай

Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн багцын 2005 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн болон Гадаад хэргийн яам, Хилийн чанадад суугаа ДТГ-ын төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг ерөнхийд нь хүлээн авч байна.

Гэвч дараах зүйлүүдийг тайландаа засварлан оруулах нь зүйтэй гэсэн саналтай байна Үүнд:

1.1 дэх хэсэгт: 2005 оны төсвийн төсөлд гадаад хэргийн яамны өөрийн үйл ажиллагааны орлогыг 55.0 сая төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд төсөв хянаж батлах явцад хасагдаж орлогын төлөвлөгөө батлаагүйн улмаас орлогын төлөвлөгөөгүй ажилласан байна.

1.2 Олон улсын байгууллагын гишүүний татварт төлөгдөх 470.1 сая төгрөгөөс Сангийн яамны төрийн сангийн газар 298.1 сая төгрөгийг төлж 172.0 сая төгрөгийг шилжүүлээгүй үлдээсэн байна.



1.3 ...Харин 2005 онд өөрийн орлого төлөвлөгөөгүй учир Сангийн сайдын 308 дугаар тушаалаар 150.0 сая төгрөгөөр орлогыг төлөвлөж нэмэгдүүлэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсныг 318.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

1.4 Хилийн чанадад суугаа ДТГ-дын орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэн тооцож орлого олох даалгавар өгөх эрх зүйн үндэсгүй, харин гүйцэтгэлийн тооцоог хянаж ажилласан байна.

2. Дипломат төлөөлөгчийн газруудын төрийн санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

3. Төсвийн төслийг үндэслэлгүй хасч баталдагийн улмаас зардлын хэтрэлт жил дараалан гарсаар байна.

Цаашид зөвлөмжид тусгагдсан асуудлын талаар тодорхой ажил зохиож дүнг Танд танилцуулах болно.

 САЙД  Н. ЭНХБОЛД

0080722

Тайлбар

Үндэсний
аудитын
газар

Тайлбар

ГХЯ-наас 2006.05.12-ны өдөр ирсэн 09/1947 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тайланд нэмж тусгах шаардлагагүй гэж үзсэн.

Дипломат албаны тухай хуулийн 4.2-т “Монгол Улсын дипломат албыг эрхлэн удирдах төрийн захиргааны төв байгууллага нь гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн”, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12.1.1-д заасны дагуу “...эрхлэх асуудлынхаа хүрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний орлого, санхүүжилтийнхээ хэрэгцээгээ бодитой тодорхойлох”, 12.1.7-д “... эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төвөлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүний нийлүүлэлт, санхүүгийн үр дүнг хянаж дүгнэх” гэсэн заалтуудын дагуу ГХЯ нь ДТГ-дын орлого, зарлагад дүн шинжилгээ хийж төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавьж байх ёстой гэж үзэж байна.

Гадаад хэргийн яамны батлагдсан төсвийн судалгаа

№	Зардлын зүйл	2003			2004			2005		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт -, хэмнэлт +	төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт -, хэмнэлт +	төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт -, хэмнэлт +
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	794,414.00	887,047.00	(92,633.00)	844,453.0	1,042,987.6	(198,534.60)	1,017,358.3	1,163,961.6	(146,603.30)
1	Туслах үйл ажиллагааны орлого	55,000.00	147,633.00	(92,633.00)	55,000.00	253,534.60	(198,534.60)		468,624.9	(146,624.90)
2	Төсвөөс санхүүжих	285,330.00	285,330.00	-	335,369.0	335,369.0	-	547,200.3	397,200.3	150,000.00
3	Олон улсын гишүүний татвар	454,084.00	454,084.00	-	454,084.00	454,084.00	-	470,158.0	298,136.4	172,021.60
			958.9	(958.90)						-
	Нийт зарлага дүн	764,484.20	888,005.90	(123,521.70)	831,374.10	961,098.30	(129,724.20)	1,017,359.0	897,771.7	119,587.30
	Ажиллагсадтай холбоотой зардал	177,191.50	155,699.00	21,492.50	208,211.40	199,849.80	8,361.60	219,132.9	227,797.1	(8,664.20)
1	Цалин хөлс болон нэмэгдэл	140,183.20	123,179.60	17,003.60	164,724.20	158,109.00	6,615.20	173,364.6	180,194.3	(6,829.70)
	Үндсэн цалин ба нэмэгдэл	126,603.00			164,724.20	158,109.00	6,615.20	173,364.6	180,194.3	(6,829.70)
	Бүтцийн өөрчлөлтөөс	13,580.20	4,050.28				-			-
2	Нийгмийн даатгалын шимтгэл	37,008.30	32,519.40	4,488.90	43,487.20	41,740.80	1,746.40	45,768.3	47,602.8	(1,834.50)
	Бараа үйлчилгээний бусад зардал	126,620.30	278,222.80	(151,602.50)	162,490.30	300,257.50	(137,767.20)	318,567.4	361,229.8	(42,662.40)
3	Бичиг хэрэг	14,250.00	24,693.50	(10,443.50)	14,250.00	31,820.20	(17,570.20)	18,306.0	35,073.9	(16,767.90)
4	Гэрэл цахилгаан	6,691.70	11,172.10	(4,480.40)	7,325.50	9,344.60	(2,019.10)	12,500.0	12,371.0	129.00
5	Түлш халаалт	17,375.10	23,876.80	(6,501.70)	22,580.30	20,599.00	1,981.30	24,000.0	23,843.1	156.90
6	Тээвэр шатахуун	9,086.00	15,675.70	(6,589.70)	9,086.00	6,589.40	2,496.60	12,300.0	18,466.7	(6,166.70)
7	Шуудан холбоо	24,650.00	37,159.30	(12,509.30)	24,650.00	32,672.60	(8,022.60)	33,560.0	35,649.0	(2,089.00)
8	Цэвэр бохир ус	1,452.50	1,411.20	41.30	1,483.50	3,822.90	(2,339.40)	4,125.7	3,685.8	439.90
9	Томилот	935.00	1,941.20	(1,006.20)	935.00	763.30	171.70	935.0	322.1	612.90
10	Гадаад арга хэмжээний зардал	43,605.00	128,857.40	(85,252.40)	73,605.00	157,286.10	(83,681.10)	182,594.0	193,804.3	(11,210.30)
11	Ном хэвлэл авах	500.00	1,227.40	(727.40)	500.00	3,079.80	(2,579.80)	1,100.0	1,994.6	(894.60)
12	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200.00		200.00	200.00		200.00	750.0	999.2	(249.20)
13	Урсгал засвар	1,500.00	7,485.90	(5,985.90)	1,500.00	1,575.70	(75.70)	2,150.0	3,151.4	(1,001.40)
14	Гадаад зочны зардал	6,375.00	18,728.00	(12,353.00)	6,375.00	32,703.90	(26,328.90)	18,146.7	20,205.0	(2,058.30)
	Төлбөр хураамж бусад хураамж		5,994.30	(5,994.30)			-	3,000.0	4,438.5	(1,438.50)
	эд хогшил худалдан авах							5,100.0	7,225.2	(2,125.20)
	Татаас ба урсгал шилжүүлэг	460,672.40	454,084.10	6,588.30	460,672.40	460,991.00	(318.60)	479,658.7	308,744.8	170,913.90
15	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,588.30		6,588.30	6,588.30	6,906.90	(318.60)	9,500.0	10,608.4	(1,108.40)
16	Олон улсын гишүүний татвар	454,084.10	454,084.10	-	454,084.10	454,084.10	-	470,158.7	298,136.4	172,022.30
	хөрөнгө оруулалтын зардал					4,635.30				-

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Дипломат төлөөлөгчийн газрын төсвийн судалгаа

/сая төгрөгөөр/

№	Зардлын зүйл	2003			2004			2005		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт -, хэмнэлт +	төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт -, хэмнэлт +	төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт -, хэмнэлт +
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	5,914.42	7,340.45	(1,426.0)	6,689.44	8,986.91	(2,297.47)	7,600.44	8,243.05	(642.61)
1	Төсвөөс санхүүжих	2,493.5	2,355.6	137.9	3,634.3	3,283.4	350.90	3,724.9	3,571.9	153.00
	орлого	4,389.9	5,881.5	(1,491.5)	3,731.4	7,137.7	(3,406.27)	5,576.8	8,295.4	(2,718.59)
2	Төрийн санд төвлөрүүлэх	969.0	896.6	72.4	676.3	1,434.2	(757.90)	1,701.3	3,624.2	(1,922.98)
	Нийт зарлага дүн	5,914.4	7,175.2	(1,260.8)	6,689.9	7,610.8	(920.92)	7,600.4	8,254.0	(653.53)
	Ажиллагсадтай холбоотой зардал	2,860.9	3,054.7	(193.8)	3,238.2	3,354.6	(116.40)	3,666.0	3,535.4	130.58
1	Үндсэн цалин ба нэмэгдэл	2,786.4	2,959.0	(172.7)	3,162.3	3,279.7	(117.33)	3,602.0	3,448.2	153.86
2	Нийгмийн даатгалын шимтгэл	74.6	95.7	(21.1)	75.9	75.0	0.94	64.0	87.2	(23.29)
	Бараа үйлчилгээний бусад зардал	3,053.5	4,120.5	(1,067.0)	3,451.6	4,256.2	(804.52)	3,934.4	4,718.5	(784.11)
3	Бичиг хэрэг	75.2	62.3	12.9	61.9	67.6	(5.72)	69.8	68.7	1.17
4	Гэрэл цахилгаан	219.4	239.3	(19.9)	249.0	243.4	5.54	269.9	257.8	12.10
5	Түлш халаалт	192.4	205.6	(13.1)	219.9	277.2	(57.31)	255.8	335.4	(79.60)
6	Тээвэр шатахуун	137.6	135.3	2.4	136.9	187.0	(50.10)	165.5	221.4	(55.94)
7	Шуудан холбоо	324.5	399.4	(74.9)	325.8	403.4	(77.54)	327.6	417.5	(89.86)
8	Цэвэр бохир ус	102.6	105.7	(3.1)	120.6	112.2	8.35	145.5	121.7	23.85
9	Томилолт	430.8	531.6	(100.8)	447.1	537.3	(90.20)	557.8	608.5	(50.65)
10	Ном хэвлэл авах	33.3	43.3	(10.0)	21.3	31.7	(10.38)	26.6	37.5	(10.88)
11	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийж	47.1	64.0	(16.8)	65.5	73.9	(8.46)	87.9	80.6	7.26
12	эд хогшил худалдан авах	42.8	212.6	(169.8)	82.4	262.6	(180.17)	75.2	264.5	(189.32)
13	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9.5	9.6	(0.1)	6.6	7.6	(1.05)	6.8	4.3	2.47
14	Урсгал засвар	123.0	466.1	(343.1)	170.3	251.6	(81.34)	142.3	379.4	(237.08)
15	Төлбөр хураамж бусад хураамж	69.5	131.3	(61.7)	3.5	111.2	(107.74)	49.0	112.8	(63.75)
16	түрээс	611.8	871.0	(259.2)	873.0	907.3	(34.30)	981.9	944.4	37.54
17	Үндсэн хөрөнгийн даатгал	87.9	101.9	(14.1)	105.1	130.5	(25.38)	127.7	127.6	0.05
18	аж ахуй, ариун цэврийн зардал	52.1	60.2	(8.1)	44.9	65.2	(20.26)	44.8	69.9	(25.13)
19	ёслолын зардал	273.1	241.8	31.3	183.1	251.2	(68.16)	182.9	248.6	(65.65)
20	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	4.4	(4.4)		6.6	(6.58)		8.8	(8.76)
3	Эрүүл мэндийн даатгал, эмчилгээ	220.6	235.1	(14.5)	334.8	328.6	6.28	417.4	409.3	

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Гадаад хэргийн яамны 2005 оны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо, Сангийн сайд Н.Баяртсайхан, Гадаад хэргийн сайд Н.Энхболд нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2006 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Гадаад хэргийн сайд Н.Энхболдод зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

Хуулбар үнэн

ТАМГЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ

С.ЛХАГВАСҮРЭН

Ерөнхий аудиторын 2006 оны тоот тушаалын
хавсралт

Төлбөр, зөрчлийн жагсаалт

№	Акт, АШ-ын	Төлбөрийн утга	Хариуцах эзний		Дүн
			албан тушаал	нэр	
1	01	Сингапур Улсад томилолтоор ажилласны томилолтын тооцооны валютын ханшны зөрүүг/сингапур доллар ба ам.долларын/ төлүүлэх	ОТХАГ-ын дэд захирал	П.Гансүх	394.8
			Азийн газрын дэд захирал	Ж.Сэрээжав	
2	02	Ирланд, Исландад ажлын айлчлал, Монгол Британийн дугуй ширээний уулзалтад оролцох томилолтын зардлыг илүү олгогдсоныг төлүүлэх	Дэд сайдаар ажиллаж байсан	А.Баттөр	6465.2
			Европын газрын даргаар ажиллаж байсан	Я.Батсуурь	
			Европын газрын атташе	Х.Мандахцэцэг	
3	03	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганд оролцож Нью-Йорк дахь БТГ-ын зочид буудалд байрлахдаа төлсөн буудлын хөлсний дүн, ГХЯ-ны санхүүд өгсөн баримтаар тушаасан мөнгөний зөрүүг төлүүлэх	ОТХАГ-ын 3 дугаар нарийн бичгийн дарга	А.Амарсанаа	950.4
		Дүн			7810.4
		Зөрчлийн утга			
4	01	Астана хотод болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын уулзалтанд оролцсон төлөөлөгчдийн томилолтын зардалд	ГХЯ-ны ТНБД-ын үүрэг гүйцэтгэгч ТЗУГ-ын захирал	Т.Батбаатар	142.5
			СЭЗХ-ийн дарга	Н.Цэрэнханд	
		Дүн			142.5
		Нийт дүн			7952.9